



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 08 сарын 11 өдөр

Дугаар А/27

Улаанбаатар хот

┌ Сүхбаатар дүүргийн Эрүүл мэндийн ┐
төвийн данс бүртгэлд хөрөнгө бүртгэх
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 3.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2021 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу хавсралтад заасан нийт 50,827,435 (тавин сая найман зуун хорин долоон мянга дөрвөн зуун гучин тав) төгрөгийн үнэ бүхий эргэлтийн бус хөрөнгийг данс бүртгэлд бүртгэн авахыг Сүхбаатар дүүргийн Эрүүл мэндийн төв (Л.Баярхүү)-д зөвшөөрсүгэй.

2. Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Сүхбаатар дүүргийн Эрүүл мэндийн төв (Л.Баярхүү)-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга (Б.Болор-Эрдэнэ)-д даалгасугай.

ДАРГА



М.БАЯРАА

11505000086*

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын даргын 2021 оны 08 дугаар сарын 11-ны өдрийн 1119/2021/35 дугаар тушаалын хавсралт



Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэх хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Сүхбаатар дүүргийн Эрүүл мэндийн төв

№	Эд хөрөнгийн нэр	Марк дугаар	Үзүүлэлт	Ашиглалтад авсан он	Чанар байдал	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Бүртгэх анхны		Хандивлагч байгууллага	
								Нэгжийн үнэ	Нийт үнэ	нэр	Эх үүсвэр
	Сүрьеэгийн нян илрүүлэх молекуляр биологийн аппарат	UVD-839124	250V-50-60HZ	2020	Сайн	ш	1	49,807,535	49,807,535	Глобал сан	
2	Шарах шүүгээ	Eurolux-5043 F	250V-50-60HZ	2020	Сайн	ш	1	669,900	669,900	Нэгдсэн Үндэсний байгууллага	хандив
3	Телевизор	Монел	220v-32 inch	2020	Сайн	ш	1	350,000	350,000	хувь хүн	
	Тоног төхөөрөмжийн дүн								50,827,435.0		

/төгрөгөөр/